



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/433


Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй
цогцолбор сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 28,732,845.40 /хорин найман сая долоон зуун гучин хоёр мянга найман зуун дөчин таван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургууль /Г.Цагаанцоож/-д зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасаж буй нийт 28,732,845.40 /хорин найман сая долоон зуун гучин хоёр мянга найман зуун дөчин таван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургууль /Г.Цагаанцоож/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

C:\Users\dashdorj\ SXD Ireedui tsogtsolbor surguuli

115050001287

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын даргын 2019 оны 11 сарын 18-өдрийн дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүрэг, Ирээдүй цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХКомиссын хурлын шийдвэр
1	Ном, сурах бичиг	4-30 жил	ш	11890		28,732,845.40	-	-	устгах
2	Номын фондын дүн			11890		28,732,845.40	-	-	
	Нийт			11890		28,732,845.40	-	-	

1119282405 1112576283